

Тэмцээний цаг

Bessie үнээ сүүний үйлдвэрлэлээсээ залхаж, компьютер тооцооллын салбарт хүч үзэхээр шийджээ. Тэрээр USACO-гийн тэмцээнд орж, өөрийнхөө программчлалын чадвараа батлахаар шийджээ. Тэмцээн 2011 оны 11-р сарын 11-ний өдөр эхлэхийг мэдсэн үнээ хөгжилтэй байхын тулд яг 11/11/11 өдрийн 11 цаг 11 минутад бодлогуудаа татаж аваад бодохоор шийдэв.

Харамсалтай нь, Bessie-ийн хувийн зохион байгуулалт нилээд муу болохоор өөртөө зориулж 3 цаг (180 минут)-аас их хугацаа үлдсэн эсэхийг мэдэх програм бичихээр шийджээ. Танд түүний ажиллаж дуусах хугацаа өгөгдөх бөгөөд, Bessie-ийн тэмцээнд зарцуулах хугацааг тооцох программ зохиоход нь тусална уу.

Input

Эхний мөр: Энэ мөрөнд зайгаар тусгаарлагдсан өдөр, цаг, минутыг тодорхойлох D, H, M гэсэн 3 бүхэл тоо өгөгдөнө.

($14 \geq D \geq 11$, $24 \geq H \geq 0$, $60 \geq M \geq 0$). Өгөгдсөн тоонууд 11-ий өдрийн 11 цаг 11 минутаас их байна.

Output

Эхний мөр: Bessie-ийн тэмцээнд зарцуулах нийт минут.

Example

Input:

12 13 14

Output:

1563

Орчуулсан УБ 1-р сургууль Б.Мөнх-Оргил